

## **МОНГОЛ УЛС-БНХАУ-ЫН ХАРИЛЦААНЫ ШИНЭ ОРЧИНД ӨВӨР МОНГОЛЫН ӨӨРТӨӨ ЗАСАХ ОРНЫ ЭЗЛЭХ БАЙР СУУРИЙН АСУУДАЛД**

*Ч.Батцэцэг\**

Монгол Улс нь мөнхийн хоёр хөрштэй, бидэнд хөршөө сонгох боломж нэгэнт үгүй болохоор хаягаа сайтар манах ёстой. Олон зуун жилийн турш айл зэргэлдээ суухдаа хөршүүд эрт дээр үеэс бие биеэ танин мэдэж, тандан судласны үндсэн дээр хоорондоо харилцаж иржээ. Иймээс бидний өвөг дээдэс өтгөс буурлууд хоёр хөршийн түүх, соёл, гүн ухаан, төрийн бодлогын судалгааг чиг баримжаа болгон өөрийн зөв мэргэн бодлогоо явуулж ирснээр өдгөө хүртэл манай улс тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлаа бататган, хамгаалж XXI зуунтай золгоод байгаа билээ. Ялангуяа урд хөрш хятадын соёл иргэншлийн талаархи монголчуудын хуримтлуулсан тодорхой ойлголт, мэдэгдэхүүн үе дамжин уламжлан баяжсаар нүүдэлчин монголчуудын дунд нэгэн цогц ойлголтыг бүрэлдүүлэн бий болгосон нь өнөөг хүртэл ач холбогдлоо алдаагүй байна. Монгол Улс өөрийн гадаад бодлогын үзэл баримтлалын үндсэн чиглэлийг тодорхойлохдоо манай улсын гадаад орчны хамгийн ойрын хүрээлэл болох хөршүүдийн харилцааг гадаад бодлогын тэргүүлэх чиглэл хэмээсэн нь ийм учиртай.

Монгол Улсын хоёр хөршийн бүрэлдэхүүнд монголчууд бидэнтэй угсаа гарваль, хэл соёл, бичиг үсэг, нүүдэлчдийн ёс заншил, ахуй амьдралын хэв маяг, үндэсний ухамсар сэтгэлгээний хувьд адил монгол үндэстэн-угсаатан бий. Иймэрхүү улс үндэстний нийтлэг зүйл нь өөр хоорондоо харилцахад маш дөхөмтэй байдаг бөгөөд тэдгээр адил төстэй үндэстнүүд түүхийн улбаанаас гол төлөв хил алгасан оршин суудаг жамтай ажгуу. Монгол Улстай хил залгаа БНХАУ-ын хойд хязгаарт орших Өвөр Монголын Өөртөө Засах Орон (ӨМӨЗО) нь хоёр улсын хилийн шугамын нийт уртын бараг 70%-ийг эзэлдэг. Манай орны зүүн болон өмнөд бүсэд оршдог Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Өмнөговь аймагтай БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр, Хянган, Шилийнгол, Улаанцав, Баяннуур, Алашаа аймаг болон Бугат хот шууд хил залгаа оршдог. БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Оронд 4,0292 сая монгол үндэстний хүн ам /2005 оны байдлаар/ 101 хошуу, 450 сум сууринд тархан суурьшиж байна.<sup>1</sup>

Одоо XXI зууны Монгол Улс - БНХАУ-ын харилцаа, стратегийн хөгжлийн шинэ орчин, нөхцөл байдалд БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны /ӨМӨЗО/ эзлэх байр суурийг тодорхойлохыг оролдоё.

\* Ч.Батцэцэг - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

XX зууны 90-ээд оноос Монгол Улс, БНХАУ-ын улс төр, эдийн засаг, соёлын болон бусад бүхий л талын харилцаа, хамтын ажиллагаа эрчимтэй хөгжиж эхэлсэн. Энэ хугацаанд хоёр талын харилцаа, бүс нутгийн хамтын ажиллагаанд ӨМӨЗО нь өөрийн газар зүйн байрлал, монгол үндэстний хэл соёлын нийтлэг өвөрмөц, давуу байдлаараа харилцааны гүүр болж ихээхэн чухал үүрэг гүйцэтгэж байгааг онцлон тэмдэглэх хэрэгтэй.

1994 онд хоёр тал “Монгол Улс, БНХАУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Гэрээ”-г шинэчлэн байгуулж, үзэглэсэн нь хоёр талын харилцааг урт хугацаанд тогтвортой хөгжүүлэх зарчим, хууль эрхийн үндсийг баталгаажуулж, харилцаа хамтын ажиллагааны үндсэн чиглэлүүдийг тодорхойлсон түүхэн ач холбогдолтой баримт бичиг болсон юм. Улмаар 1998, 1999 оны дээд хэмжээний уулзалт тухайлбал Монгол Улсын ерөнхийлөгч Н.Багабанди болон БНХАУ-ын дарга Зян Зэмин нарын яриа хэлэлцээ, 1998 онд гаргасан “Монгол, Хятадын хамтарсан мэдэгдэл” нь хоёр орны харилцааг XXI зуунд хөгжүүлэх үндсэн чиглэлийг тодорхойлж өгсөн билээ. Хоёр талын удирдагчдын дээд хэмжээний харилцан айлчлал тасралтгүй нэмэгдэж, хоёр улсын харилцаа хамтын ажиллагаа шинэ түвшинд хүрсэн нь хоёр улсын харилцан ойлголцол, итгэлцлийг улам бэхжүүлж, бүх талын харилцан ашигтай, хамтын ажиллагааг өргөжүүлэн тэлэхэд чухал ач холбогдолтой болж байна. Нөгөөтэйгүүр БНХАУ-д манай улсын төрийн тэргүүн ерөнхийлөгч, ерөнхий сайд болон бусад албаны төлөөлөгчид айлчлахдаа ӨМӨЗО-оор заавал зочилдог, БНХАУ-аас манай улсад төрийн айлчлал хийх төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд ӨМӨЗО-ы засгийн газрын хийгээд төрийн албаны хүмүүс багтдаг уламжлал нэгэнт тогтсон нь хоёр улсын харилцаа, хамтын ажиллагаанд Өвөр Монголын эзлэх байр суурийг тодорхойлж байгаа хэрэг юм. Ийнхүү ӨМӨЗО-ы үе үеийн тэргүүн нар манай улсад айлчилж, хоёр орны сайн хөршийн, харилцан итгэлцсэн түншийн харилцааны зарчимд тулгуурласан харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд БНХАУ-ын ӨМӨЗО-ны бүх шатны байгууллага, иргэд, төрийн бус байгууллага үнэтэй хувь нэмэр оруулж байна.

Өнөөдөр Монгол Улс, БНХАУ-ын ӨМӨЗО-ы хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа нь төр засаг, албан байгууллага, уул уурхай, эрчим хүч, мал аж ахуй, хөдөө аж ахуй, барилгын салбар, аж ахуйн нэгж, аймаг сум, хот, дүүрэг, цагдаа цэрэг, олон нийтийн төрийн бус төрөл бүрийн байгууллага, шинжлэх ухаан-техникийн салбар, их дээд, бага, дунд сургууль, урлаг соёл, хэвлэл, биеийн тамир спорт, эмнэлэг, нийтийн ахуй үйлчилгээ, худалдаа, хоол хүнс, үчин гоо сайхан, хувь хүмүүс гээд ер нь бүхнийг хамарч байна. Үүний онцлог,

өвөрмөц байдал нь үндэс угсаа, хэлний адил төстэйн давуу тал, харилцан ойлголцох боломж, ахуй байдлын нөхцөл байдал ихээхэн нөлөөлж байгаатай шууд холбоотой. Ойрын түүх сөхөхөд, 90-ээд оны эхээр манай ард иргэд гадаадад чөлөөтэй зорчих болж, юуны өмнө урд хөршийн нутаг дэвсгэрт анх хөл тавихад манайхаас тэс өөр хэл бичиг, ахуй соёлын өвөрмөц нөхцөл байдал угтаж авсан. Ийм байдалд анх өвөр монголчууд биднийг угтан авч, хэл залгуулан, аливаа хүндрэл, бэрхшээлийг гэтлэн давахад тусалж, улмаар өөр хоорондоо харилцан, хоёр талын монголчууд бие биеэ танин мэдэж, ухамсар сэтгэлгээний өөрчлөлт, онцлог ялгааг мэдэрч эхэлсэн гэж хэлж болно. Өвөр монголчууд ч монгол үндэстнээр бахархах сэтгэл өвөрлөн манай улсад янз бүрийн ажлаар зорчдог болсон ба эхний үед голдуу сэхээтнүүд хэлмэрч зуучлалаар ирж байв. Гэтэл манайхны зарим хүмүүс тэднийг “хужаа” хэмээн нэрлэж гомдоосон явдал нэлээд гарч байсан ба одоо ч энэ байдал хэвээр үргэлжилж байгаа. Энэ үеэр өвөр монголын зарим тэрслүү үзэлтнүүд манай орноор дамжин гурав дахь орон руу гарч явсан тохиолдол ч хэд хэд бий. Тэр үед манай ард иргэд зах зээл, худалдаа арилжааны арга барилд туршлага муутай байсан авч аажимдаа суралцаж, өвөр монголчуудад гэнэн цагаан сэтгэлээр хандаж байв. Өвөр монголчууд угаас тэвчээртэй, хөдөлмөрч, арилжаа наймааны арга барилд аль хэдийнээ гаршсан байлаа. Ийнхүү хоёр талын ард иргэд хамтран худалдаа арилжаа эрхлэх, аж ахуйн нэгж байгуулах ажлыг эхлүүлж байсан бөгөөд энэ хугацаанд хоёр талын хувь хүмүүс болон аж ахуйн нэгж, компаниудад үл ойлголцол, хууль тогтоол, дүрэм журмын буруу зөрүүгээс үүдсэн элдэв маргаан, бэрхшээлтэй тулгарч байв. Тухайлбал: Өвөр Монголдоо нэрд гарсан аж ахуйн нэгж Ши Чи корпораци, Ордос корпораци, Сай Бан хувцасны хувьцаат компани, Баяннуур аймгийн ноос ноолуур боловсруулах аж ахуйн нэгжийнхэн манай улсын зах зээлд ар араасаа цувран орж байсан.<sup>2</sup> Гэвч тэдгээр нь ямар ч үр ашгаа өгөөгүйгээр барахгүй хөрөнгө нийлүүлэгчдийн хоорондын маргаанаас болж Монголд хөрөнгө оруулсан өвөр монголчуудыг хохироож, урам зоригийг хугалсан явдал ихээхэн гарсан билээ. Харин анх Бээжин хотоор зорчих манайханд үйлчилж байсан өвөр монголчууд өдгөө хөлжиж, өөрийн аж ахуйн нэгжийг байгуулан хөл дээрээ зогссон байна. Өвөр монголчуудын энэ ажил одоо ч хүртэл үргэлжилж, хөдөө орон нутгаас залуус олноороо Бээжинд ирэх болжээ. Манай ганзагын худалдаа эрхлэгчдийн цуваа ч мөн адил үргэлжилсээр ... Ялангуяа хоёр талын хилийн худалдаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжийн дийлэнхийг хувийн хэвшлийнхэн эзэлж, томоохон аж ахуйн нэгж, компани тун цөөн байлаа. Эдгээр жижиг аж ахуйн нэгжийн барааны

эргэлтийн хөрөнгө мөнгө тааруухан, хүчин чадал маруухан учраас өр төлбөрөө цаг тухайд нь хийж чаддаггүй, аль болох л үнэ хямд төсөр, чанар чансаа муутай бараа хүнс, жимс ногоо, гурил будаа, элсэн чихэр оруулж, хоёр улсын засгийн газар хоорондын гэрээний дагуу нийлүүлсэн чанартай, баталгаатай барааны нэр хүндийг бууруулах явдал гарсаар байв.

Монгол Улсаас БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хөх хотод суугаа Ерөнхий Консулын газрыг 1990 онд сэргээн, мөн 1996 онд Эрээн /Эрлянь/ хотод Монгол Улсын Консулын газрыг байгуулсан. 1992 оноос Улаанбаатар-Хөх хотын агаарын нислэгийн шугамыг нээж, 1992 оны хавраас Замын-Үүд-Эрээний чиглэлийн нийтийн тээврийн үйлчилгээг явуулж эхэлсэн. Одоо Монгол, Хятад хоёр улсын хилийн дагуу байнгын буюу улирлын чанартай 13 хилийн боомт үйл ажиллагаа явуулж байгаагийн 10 нь ӨМӨЗО-той хиллэж байна. Хоёр талын хилийн боомт нээгдснээр эдийн засаг худалдааны хамтын ажиллагаа улам өргөжиж, хилийн худалдаа, аялал жуулчлал, орон нутгийн үйл ажиллагаа, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, компани, ард иргэд, хувь хүмүүсийн явдал суудалд ихээхэн ач тусаа өгч, чухал үүрэг гүйцэтгэж байна. Тухайлбал 2008 онд Монгол Улс нь БНХАУ-ын ӨМӨЗО-ы хоорондын худалдааны нийт эргэлт 9,94 сая ам. долларт хүрч 46,8%-иар нэмэгдэж, манай улс ӨМӨЗО-ы худалдааны хоёрдахь том түнш нь болжээ.<sup>3</sup>

Орон нутгийн аймаг, хот, сумын засаг захиргааны хооронд гэрээ хэлцэл хийж, шууд хамтран ажиллаж, бие даасан үйл ажиллагаа явуулж байгаа нь тухайн орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэхэд асар их ач холбогдолтой юм. Үүнтэй холбогдуулан зөвхөн нэг аймгийг жишээлэн авч үзье. Сүхбаатар аймаг нь БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймаг, Зүүн Үзэмчин хошуу, Хөлөнбуйр зэрэг аймагтай шууд харилцаа холбоотой ажиллаж улмаар аймаг хошууны тэмдэглэлт ой, улсын хэмжээний баяр наадамд уран бүтээлчдээ солилцдог байна. Тухайлбал: 2007 оноос жил бүр хоёр орны зохиолч, яруу найрагчдын уулзалт наадмыг хамтран, тогтмол явуулж, аймгийн угсаатны зүйн музей, уран зураачдын үзэсгэлэнг БНХАУ-ын Шилийн гол аймаг болон Зүүн Үзэмчин хошуунд гаргажээ. 2010 онд Монгол Улс, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойн хүрээнд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Зүүн-Үзэмчин хошууны “Улаан мөчир” хамтлаг, ахмадын сайн дурын уран сайханчид Сүхбаатар аймгийн Баруун-Урт хот, Эрдэнэцагаан сумдад, Сүхбаатар аймгийн “Жаахан Шарга” театрийн уран бүтээлчид БНХАУ-ын ӨМӨЗО-ны Зүүн-Үзэмчин хошуунд бүрэн хэмжээний тоглолт тус тус хийжээ. Сүхбаатар аймгийн оюутан сурагчид 2004 оноос БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр аймгийн их сургуульд оюутан солилцооны шугамаар 2,5 жилийн хятад хэлний

бэлтгэл ангид сурч, нийт 20 гаруй залуучууд суралцаад байна. Үүнээс хоёр улсын харилцаанд орон нутгийн шууд харилцаа ямар их ач холбогдолтой гэдгийг харж болох юм.

1978 оноос БНХАУ-д өөрчлөлт шинэчлэл, нээлттэй бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн ч үндэстний цөөнхийн оршин суух бүс нутаг харьцангуй хаалттай байлаа. Тиймээс Өвөр Монгол дахь монгол үндэстний ардын язгуур урлаг, утга зохиол, соёлын салбарын үйл ажиллагаа, соёлын гадаад харилцааны хөгжил нэлээд хоцрогдонгуй түгжигдмэл байсан гэж хэлж болох байх. 90-ээд оноос Монгол Улс хөрш орнуудынхаа бүс нутгийн хил орчмын монгол үндэстэн-угсаатанд өөрийн нүүдэлчин монгол үндэстнийхээ соёлын өв уламжлалаас заан сургаж улмаар түүнийг бататган баяжуулах, сэргээн хөгжүүлэх, дэлгэрүүлэх үйлст нь идэвхтэй үүрэг гүйцэтгэж, соёлын асар их хөрөнгө оруулалтыг хийсэн юм. (Энэ тухай Өвөр Монголын судлаачид, өвөр монголчууд бахархан ярьж бичиж буй). Гэтэл одоо эргээд тэдэнтэйгээ заргалдах хэрэг гараад ирлээ. Учир нь 2000 оноос Хятадын засгийн газраас БНХАУ-ын баруун бүсийн нутгийг хөгжүүлэх төсөл, үндэстний бодлогын хүрээнд үндэстний цөөнхийн бүс нутаг ӨМӨЗО, ТӨЗО, ШУӨЗО-ы эдийн засгийн бүтээн байгуулалт, байгаль экологийг нөхөн сэргээх ажил, аялал жуулчлал, үндэстний соёлын өв уламжлалыг нь хөхиүлэн дэмжиж, сэргээн хөгжүүлэхэд асар их хөрөнгө оруулалтыг хийж байгаа билээ. Энэ бодлогын хүрээнд тухайлбал Өвөр Монголын нутаг дэвсгэрт монголын түүхэнд холбогдох газруудыг хамгаалалтандаа авахын зэрэгцээ бүтээн байгуулалтыг хийж, аялал жуулчлалыг өргөжүүлэн хөгжүүлж байна. Тухайлбал: Хятадын хамгаалалтанд авсан эд өлгийн зүйлс, түүх, соёлын дурсгалт газруудаас нэрлэвэл, Ордос дахь “Чингисийн онгоны цогцолбор”, Шилийн гол аймгийн аялал жуулчлалын “Асгат” бааз, Зүүнгар хошууны аялал жуулчлалын бааз, Ордос хотын Зүүнгар хошууны Зүүнгар зуу сумын нутагт оршдог “Эрдэнэ болорт сүм” (Мин улсын үед “Баозансы хийд”, Чин улсын үед “Баотансы хийд” хэмээн нэрлэж байсан), Баарин чулуу (ӨМӨЗО-ы газар зүйн бэлгэ тэмдэгт бүтээгдэхүүн болгож хамгаалалтанд авсан. Тамганы чулуу), Өвөр Монголын Саньхэ адууны шинжлэх ухаан технологийн музей (Саньхэ адууны шилдэг үүлдэр угсааны түүх соёлын өвөөр хадгалагдсан, дэлхийн 500 брэндэд багтсан) гм.

Үүний сацуу монгол үндэстний соёлын өв, уламжлал, биет бус соёлын өвийг БНХАУ өөрийн нэрээр ЮНЕСКО-д бүртгүүлж эхэлсэн юм. БНХАУ нь соёлын бодлогыг улс төр, эдийн засгийн бодлоготой эн тэнцүү авч үздэг. 2005 онд Монгол Улс, БНХАУ-тай хамтарч монгол үндэстний уртын дууг ЮНЕСКО-д бүртгүүлж, дэлхийн түүх, соёлын өв санд үнэтэй хувь нэмэр оруулсан монгол үндэстэн, нүүдэлчдийн соёл

иргэншлэлийг дэлхий дахинд таниулах анхны алхам боллоо гэж хоёр тал үзсэн юм. Дараа нь 2009 онд БНХАУ дангаараа монгол үндэстний хоолойн цоорыг /хөөмэй/ өөрийн нэр дээр ЮНЕСКО-д бүртгүүлснээр асуудал үүсэв. Хоолойн цоор нь хөөмийтэй төстэйвтэр Алтайн нурууны эргэн тойронд оршин суух монгол үндэстний дунд үүссэн гэж үздэг. Энэ талаархи мэдээллийг манай хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр дамжуулан хүлээн авсан ард түмэн дургүйцэж, монголчууд бидний соёлын өв уламжлалыг хятадууд авч байгаа мэтээр андуу ташаа ойлгон, бичиж ярьж шуугисан юм. ЮНЕСКО-гийн зорилго нь тухайн улс үндэстэн өөрийн соёл, өв уламжлал, ардын зан заншлаа хадгалан дээдэлж, цаашид хэрхэн дэлгэрүүлэн сурталчилж, хөгжүүлэн баяжуулж буйг харгалзан тухайн улс үндэстний нэр дээр бүртгэж, дэлхийн өв санд хадгалан тунхаглаж байгаа хэрэг. Гэтэл БНХАУ-д аж төрдөг монгол үндэстний ард түмэн бас өөрийн үндэсний уламжлал, зан заншил, соёлын өв, эд өлгийн баялгаа хадгалсаар өдгөө хүрсэн билээ. Харин тэдгээрийг хөгжүүлэхэд манай улсын соёл, урлагийн нэртэй хүмүүс, мэргэжилтэн, багш нар ихээхэн нэмэр хандив болж Өвөр Монголд очиж ажиллан, зааж сургаж, Өвөр Монголоос манай оронд оюутан сурагчид ирж идэвхтэй, хичээнгүй сайн суралцаж, овсгоо самбаатай ажилласны үр дүн гарч байгааг хэлэх хэрэгтэй. Ийнхүү ниргэсэн хойно нь хашгирав гэгчийн үлгэр болсон билээ. Одоо Монгол Улс, БНХАУ-ын монгол үндэстэнтэй холбогдох соёлын өвийг бүртгүүлэхдээ харилцан ярилцсны үндсэн дээр шийдвэрлэх, соёлын өвийн эд өлгийн зүйлийг хил дамнуулан худалдаалахын эсрэг хамтран ажиллахаар тохиролцоод байна.

Нөгөөтэйгүүр энд Өвөр Монголын хөрөнгө оруулалт манай шинжлэх ухаан-технологи, соёл, боловсролын салбарын хөгжилд хувь нэмрээ оруулж байгааг дурьдах нь зүйтэй. ӨМӨЗО-нд манай 2000 оюутан сурч байгаагийн 47 хувь нь Өвөр Монголын Засгийн газрын тэтгэлгээр суралцаж байна. 2010 онд Монгол Улс, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойн хүрээнд ӨМӨЗО-ы тэргүүн Баатар, ӨМӨЗО-ны АТИХ-ын Байнгын хорооны дарга, намын сахилга батыг хянан шалгах хорооны нарийн бичгийн дарга Хэ Гуоцян тэргүүтэй ӨМӨЗО-ы холбогдох албаны хүмүүс хүрэлцэн ирсэн юм. Айлчлалын үеэр талууд хөдөө аж ахуй, боловсрол, зам, тээвэр, барилга, хот байгуулалтын салбарт хамтран ажиллах хэд хэдэн чухал баримт бичигт гарын үсэг зуржээ. Мөн уул уурхай, эрчим хүч, газар тариалан, боловсрол, дэд бүтцийн салбарт БНХАУ-ын аж ахуйн нэгжүүд хөрөнгө оруулах, шороон шуурга, ялангуяа цөлжилттэй тэмцэх, аймаг, сум, иргэд, төрийн бус байгууллагын шууд харилцааг хөхиүлэн дэмжих, Замын-Үүдийн чөлөөт бүсэд хөрөнгө оруулах,

улирлын чанартай зарим боомтыг байнгын ажиллагаатай болгох зэрэг чиглэлээр харилцан ашигтай хамтарч ажиллах саналыг талууд дэвшүүлж, дээрхи ажлыг хэрэгжүүлэхэд ӨМӨЗО ихээхэн хувь нэмэр оруулах тухай ярилцсан байна.<sup>4</sup> ХКН-ын ХҮП их хурлаас “Хятад улс нь хөрш орнуудын хувьд бид найрамдал, түншлэлийн харилцааны бодлогоо үргэлжлүүлж, сайн хөршийн харилцаа, бодит хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэх. Бүс нутгийн аюулгүй, тогтвортой орчныг хамтран байгуулахын төлөө бүс нутгийн хамтын ажиллагааг эрчимтэй хөгжүүлэх. Өөрийн бололцооны хэрээр хөгжиж буй орнуудыг тусалж дэмжих, хөгжиж буй орнуудын нийтлэг эрх ашиг, хууль эрхийн шаардлагыг хангахын төлөө ажиллахаа”<sup>5</sup> мэдэгдсэн байгаа.

Тэгээд ч яг одоо манай улс БНХАУ-тай зэрэгцэн хөгжих боломж нэгэнт бүрэлдэн тогтож, хоёр улс стратегийн түншлэлийн хэмжээнд харилцааар ярилцаж, тохиролцож байна. Иймээс Өвөр Монголын хөрөнгө оруулалтыг оновчтой газар нь хэрэгжүүлэх, манай улсын мал аж ахуй, хөдөө аж ахуй, газар тариалангийн салбар, байгаль орчныг хамгаалах, цөлжилттэй тэмцэх, шороон шуурга, бэлчээр нутгийг хамгаалах, талхлагдсан газрыг нөхөн сэргээх, дэд бүтэц, хилийн боомт, орон нутгийн бүтээн байгуулалт эмнэлэг-үйлчилгээ болон орон нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх үйлст зарцуулахад илүү тохиромжтой юм. Хоёр талын орон нутгийн шууд харилцааг хөхиүлэн дэмжиж, харилцан туршлага солилцох, хоёр талын давуу талыг ашиглах нөхцлийг бүрдүүлэх явдал мөн чухал байна. XXI зуунд Монгол орон ашигт малтмал, байгалийн их нөөцөө ашиглаж эхэлсэнтэй холбоотойгоор их гүрнүүдийн өрсөлдөөний бай болж, тэдний эдийн засгийн ашиг сонирхлыг төвлөрүүлсэн цоо шинэ орчин бүрэлдэн тогтож байна. Энэ үеэс Монгол Улсын уул уурхайн салбарт БНХАУ нь хөрөнгө оруулалт хийхдээ Өвөр Монголын уул уурхайн компаниудаас эхлүүлэн оруулж байсан юм. Одоо бол БНХАУ-ын ӨМӨЗО-оос манай улсад оруулж байгаа хөрөнгө оруулалтын хэмжээ жил бүр өсч Монгол Улс, БНХАУ-ын хооронд хийгдэж буй худалдааны 80 гаруй хувийг ӨМӨЗО<sup>6</sup> дангаараа эзэлж байна. ӨМӨЗО-ны нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 4638 ам долларт хүрсэн байна. Гэвч өнөөдөр Өвөр Монгол нь БНХАУ, Монгол Улсын хооронд зөвхөн гүүрийн үүрэг гүйцэтгээд Монгол Улстай шууд залгаа өртөө засах орны хувьд бие даасан үйл ажиллагаа явуулан, ихээхэн хөрөнгө оруулалт хийж, томоохон бүтээн байгуулалтанд оролцоогүй байгаадаа засгийн газар нь дүгнэлт хийж, хэрхэх талаар судалгааны ажил явуулж байна.

Эцэст нь ардчиллын замаар замнаж буй тусгаар тогтносон, бүрэн эрхт Монгол Улс нь монгол үндэстний гол цөм болохоор дэлхийн улс гүрний харъяанд тархан суурьшсан бусад монгол үндэстнээр өөрийгөө

хүрээлүүлэх, монгол нүүдэлчдийн соёлын өв, эд өлгийн зүйлсийг хамгаалан бэхжүүлэх, өв уламжлал, соёлынхоо хил хязгаарыг тэлэхийн тулд тэднийг хүндэтгэн үзэж, цааш түлхэх бус аль болохоор эээр татах бодлого явуулах ёстой. Үүний тулд эхлээд манай орны нийгмийн сэтгэл зүй, олон нийтийн ухамсар сэтгэлгээн дэх хятадын эсрэг үзэл, “хужаа”, “хятадын аюул” гэсэн уур амьсгалыг намжааж байж сая хоёр орны жирийн ард иргэд түүн дотор Өвөр Монгол дахь монголчуудын хоорондын найрсаг харилцааг улам сайжруулан бэхжүүлэх болно. Үүний тулд эхлээд БНХАУ-ын хэмжээнд эдийн засгийн есөлтөөрөө сүүлийн 8 жилийн турш тэргүүлж буй ӨМӨЗО-ы хөгжлийн туршлага, чиг хандлагыг судалж, зөвхөн хоёр орны гүүрийн хэмжээнд бус ӨМӨЗО-ы өөрийн нь байр суурийг Монгол-Хятадын харилцааны шинэ орчинд тодорхойлж гаргах нь зүйтэй болов уу.

### ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Хао Вэйминь. Өвөр Монголын товч түүх. /Нэй мэngu тунши/ Бээжин., 2006. т.655
2. “Монгол Улс, БНХАУ-ын ӨМӨЗО-ны найрсаг харилцаа, хамтын ажиллагаа” Хөх хот, 2001.,т.22
3. Монгол-Хятадын харилцаа жарнаас жаранд 1949-2009. УБ.,2010.,т.84
4. <http://www.open-government.mn/>
5. ХКН-ын 17-р их хурлын материалаас
6. <http://www.president.mn/>